

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 26 оны 08. сарын 20. өдөр

№ R-2026-37

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2026 оны 08 дугаар сарын 19-20-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар 88.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 18.4%-д хүргэж ажилласан болохыг;
2. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2026 оны эхний хагас жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (“Хагас жилийн ногдол ашиг”)-ыг ТУЗ-д санал болгосныг; мөн
4. ТУЗ нь Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.


ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.0 (арван найм) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг тухайн хурал зохион байгуулагдах хэлбэрээс үл хамааран Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Хагас жилийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь бичгээр

урьдчилан хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ, ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ